



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 424. | Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 01 | 1742 |
| 425. | Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай | Дугаар 02 | 1745 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|------------|------|
| 426. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох, чөлөөлөх тухай | Дугаар 107 | 1745 |
| 427. | Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай | Дугаар 108 | 1746 |
| 428. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 119 | 1747 |
| 429. | Анхдугаар чуулганыг товлон зарлах тухай | Дугаар 123 | 1748 |
| 430. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 124 | 1749 |
| 431. | Орон тооны бус зөвлөхөөр томилох тухай | Дугаар 128 | 1749 |
| 432. | Албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 129 | 1750 |
| 433. | Д.Баттулгыг албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 133 | 1750 |
| 434. | Албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 134 | 1751 |
| 435. | Албан тушаалд томилох тухай | Дугаар 135 | 1751 |
| 436. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 145 | 1752 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|-------------------------|------------|------|
| 437. | Журам батлах тухай | Дугаар 139 | 1752 |
| 438. | Тэмдэглэлт өдрийн тухай | Дугаар 140 | 1755 |

439.	Журам батлах тухай	Дугаар 141	1755
440.	Говийн бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай	Дугаар 144	1766
441.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги батлах тухай	Дугаар 146	1767
442.	Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам батлах тухай	Дугаар 150	1787
443.	Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай	Дугаар 151	1790
444.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 152	1791
445.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 153	1792
446.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 154	1794
447.	Төмөр замын суурь бүтцийг барих концессион гэрээний тухай	Дугаар 161	1798
448.	Монгол Улсын хувьцааг нэмэгдүүлэх тухай	Дугаар 165	1800

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 07 дугаар Дугаар 01 Улаанбаатар
сарын 06-ны өдөр хот

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6



дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон дор дурдсан нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй:

- 1/Норовын Алтанхуяг
- 2/Ринчинямын Амаржаргал
- 3/Агыпарын Бакей
- 4/Нямжавын Батбаяр
- 5/Сундуйн Батболд
- 6/Сүхбаатарын Батболд
- 7/Жалбасүрэнгийн Батзандан
- 8/Жамъянсүрэнгийн Батсуурь
- 9/Халтмаагийн Баттулга
- 10/Догсомын Батцогт
- 11/Намдагийн Батцэрэг
- 12/Мигэддоржийн Батчимэг
- 13/Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- 14/Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
- 15/Зангадын Баянсэлэнгэ
- 16/Гарьдхүүгийн Баярсайхан
- 17/Цэвэлмаагийн Баярсайхан
- 18/Сангажавын Баярцогт
- 19/Лувсанвандангийн Болд
- 20/Баярбаатарын Болор
- 21/Хаянгаагийн Болорчуулун
- 22/Раднаагийн Бурмаа
- 23/Сандагийн Бямбацогт
- 24/Сайнхүүгийн Ганбаатар
- 25/Дашдондогийн Ганбат
- 26/Лувсаннямын Гантөмөр
- 27/Даваажавын Ганхуяг
- 28/Батхүүгийн Гарамгайбаатар
- 29/Раднаасүмбэрэлийн Гончигдорж
- 30/Цэрэнпилийн Даваасүрэн
- 31/Цэдэвийн Дашдорж
- 32/Дамдингийн Дэмбэрэл
- 33/Самбуугийн Дэмбэрэл

- 34/Мөнхчулууны Зоригт
35/Данзангийн Лүндээжанцан
36/Батсүхийн Наранхүү
37/Нямтайширын Номтойбаяр
38/Цэндийн Нямдорж
39/Салдангийн Одонтуяа
40/Ёндөнгийн Отгонбаяр
41/Санжаасүрэнгийн Оюун
42/Цэдэвдамбын Оюунгэрэл
43/Дуламсүрэнгийн Оюунхорол
44/Ядамсүрэнгийн Санжмятав
45/Чимэдийн Сайханбилэг
46/Янгугийн Содбаатар
47/Отгонбилэгийн Содбилэг
48/Мишигийн Сономпил
49/Алмаликийн Тлейхан
50/Шаравдоржийн Түвдэндорж
51/Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
52/Дэндэвийн Тэрбишдагва
53/Чүлтээмийн Улаан
54/Гантэмөрийн Уянга
55/Дамдингийн Хаянхярваа
56/Чимэдийн Хүрэлбаатар
57/Ухнаагийн Хүрэлсүх
58/Логийн Цог
59/Баттогохын Чойжилсүрэн
60/Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
61/Жадамбын Энхбаяр
62/Зандаахүүгийн Энхболд
63/Миеэгомбын Энхболд
64/Нямаагийн Энхболд
65/Өлзийсайханы Энхтүвшин
66/Содномзундуйн Эрдэнэ
67/Дондогдоржийн Эрдэнэбат
68/Жаргалтулгын Эрдэнэбат
69/Лувсангийн Эрдэнэчимэг

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 07 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2012 оны 7 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Л.ЦОГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 32.6, 58 дугаар зүйлийн 58.1.2, 58.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Банзрагчийн Дашдондовыг Увс аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Зундуйн Энхтуяаг Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Мягмарсүрэнгийн Мандахбаярыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Чойндолонгийн Даваасүрэнг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус томилсугай.



2. Содовын Цэрэндуламыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, Лхагвын Энхтайваныг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан томилсугай.

3. Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Банзрагчийн Дашдондовыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Зундуин Энхтуяаг Говьсүмбэр аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

4. Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Баасанхүүгийн Лхамхүүг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

**Шүүгчийн бүрэн эрхийг
түдгэлзүүлэх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.5, 57.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Аюушийн Отгончимэгийг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 119

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол хүн эх орондоо эрүүл, аюулгүй амьдрах таатай орчинг бүрдүүлэх, гэр бүл, өсвөр үеийн эрүүл тогтвортой хөгжлийг хангах, хүн амын өсөлт, удмын санг сайжруулах, ажиллах хүчний хэрэгцээг зохицуулах төрийн нэгдмэл бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлж, эрх зүйн орчныг сайжруулахын тулд Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг.Хүн амын тогтвортой өсөлтийн үндэс болсон эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл чийрэг өсч торних эдийн засаг, нийгмийн бүхий л тогтолцоог боловсронгуй болгох үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг чиглэл болгосугай:

1.1.Хүүхэд төрүүлсэн болон үрчилж авсан эх /эцэг/, хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийг 2 нас хүртэл сар бүр 100 мянган төгрөгийн тэтгэлэг олгох.

1.2.Хүүхэд төрүүлсэн болон үрчилж авсан эх /эцэг/, хууль ёсны асран хамгаалагчийг орон сууцны хөтөлбөрт тэргүүн ээлжинд хамруулж, тодорхой хөнгөлөлт өдлүүлэх.

1.3.Улсын хэмжээнд бага насны хүүхдийг асран хүмүүжүүлэх цэцэрлэг барьж байгуулах төсвийг хүн амын нягтрал, өсөлт, бусад судалгаанд үндэслэн жил бүрийн төсөвт тусгаж, тасралтгүй хэрэгжүүлэх, асран хүмүүжүүлэгч багш нарын цалинг нэмэгдүүлж, хөнгөлөлт урамшууллын системийг шинэчлэн сайжруулах.

Хоёр.Гадаадад сурч, ажиллаж, аж төрж буй Монгол Улсын иргэд, харьят, уугуул, тэдгээрийн гэр бүл, үр хүүхдийг эх орондоо эргэж ирэх, суурьших, ирж очих, ажиллаж амьдрах, хөрөнгө

оруулахад эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх.

Гурав. Монгол үндэстэн, угсаатнуудыг Монгол Улсад ирж хөдөлмөрлөх, сурх, амьдарч суурьших бололцоогоор хангах ажлыг үе шаттайгаар, сонголттойгоор гүйцэтгэх эрх зүй, хөрөнгө санхүү, зохион байгуулалтын арга хэмжээг тооцоо, судалгааны үндсэн дээр хэрэгжүүлэх.

Дөрөв. Дээрх зорилтыг ажил хэрэг болгох төрийн нэгдмэл бодлогыг боловсруулах ажлын хэсгийг зохих нөхцөл бололцоо, удирдлага чиглэлээр хангаж ажиллахыг Засгийн газарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

**СҮХБААТАРЫН
БАТБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар
хот

**Анхдугаар чуулганыг товлон
зарлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 4, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганыг 2012 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 10.00 цагт товлон зарласугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Камбожийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Тогтохбаярын Батбаатарыг эгүүлэн татах, Камбожийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Түвдэндоржийн Жанабазарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар
хот

Орон тооны бус зөвлөхөөр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цагааны Оюундарийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөхөөр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 129

Улаанбаатар
хот

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар батлагдсан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд ажиллах болсонтой холбогдуулан Мигэддоржийн Батчимэгийг Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын бодлогын зөвлөхийн, Цэдэвдамбын Оюунгэрэл, Раднаагийн Бурмаа нарыг Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөхийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 133

Улаанбаатар
хот

Д.Баттулгыг албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар батлагдсан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Дашжамцын Battulgыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар
хот

Албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар батлагдсан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Пунцагийн Цагааныг Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх, хуулийн бодлого, эрдэс баялаг, эрчим хүчний бодлогын зөвлөхийн албан тушаалаас тус тус чөлөөлж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар
хот

Албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар батлагдсан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жигмиддашийн Баярцэцэгийг Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөхийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 07 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бруней Даруссалам Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пүрэвжавын Гансухийг эгүүлэн татаж, Бруней Даруссалам Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Дэлгэрмааг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 8.5, 8.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түүхий нүүрс олборлодог аж ахуйн нэгж, байгууллагыг агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД

Д.ЗОРИГТ



Засгийн газрын 2012 оны 139 дүгээр
тогтоолын хавсралт

**ТҮҮХИЙ НҮҮРС ОЛБОРЛОДОГ АЖ АХҮЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫГ АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРӨӨС
ЧӨЛӨӨЛӨХ, ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор түүхий нүүрс олборлодог аж ахуйн нэгж, байгууллагыг агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Олборлосон нүүрснийхээ 70-аас доошгүй хувийг дулааны цахилгаан станцын тасралтгүй найдвартай ажиллагааг хангахад зориулан нийлүүлж, эрчим хүчиний системийн нүүрсний нийт хэрэглээний 20-иос доошгүй хувийг дангаараа хангаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор түүхий нүүрс олборлодог аж ахуйн нэгж, байгууллага гэдэгт хамруулна.

1.3. Эрчим хүчиний тухай хуулийн 3.1.11-д заасны дагуу төв суурин газрын нийт хэрэглээний 50 хувиас дээш хэсгийг шугам сүлжээгээр дамжуулан хангах үйл ажиллагааг эрхэлж байгаа дулааны төвлөрсөн хангамжийн эх үүсвэрт нүүрс нийлүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор түүхий нүүрс олборлодог аж ахуйн нэгж, байгууллага гэдэгт хамруулна.

Хоёр. Агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлөх,
хөнгөлөлт үзүүлэх талаар

2.1. Энэ журмын 1.2-т заасан аж ахуйн нэгж, байгууллагыг агаарын бохирдлын төлбөрөөс бүрэн чөлөөлнө.

2.2. Энэ журмын 1.3-т заасан түүхий нүүрс олборлодог аж ахуйн нэгж, байгууллагыг мөн зүйлд заасан дулааны төвлөрсөн хангамжийн эх үүсвэрт нийлүүлсэн нүүрсний хэмжээгээр нь агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ.



2.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь дараахь баримтыг бүрдүүлсний үндсэн дээр агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлүүлэх болон хөнгөлөлт эдлэх хүсэлтийг дараа оны I улиралд багтаан харьяалагдах татварын албанд хүргүүлнэ:

2.3.1. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3-т заасан мэдээ тайланг хугацаанд нь гаргаж өгсөн талаар нүүрсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт;

2.3.2. агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлүүлэх аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 1.2-т заасан дулааны цахилгаан станцуудтай өмнөх онд байгуулсан нүүрс нийлүүлэх, худалдан авах гэрээг дүгнэж тооцоо нийлсэн тухай баримт;

2.3.3. агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт эдлэх аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 1.3-т заасан төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай өмнөх онд байгуулсан нүүрс нийлүүлэх, худалдан авах гэрээг дүгнэж тооцоо нийлсэн тухай баримт.

2.4. Энэ журмын 2.3-т заасан баримтыг бүрдүүлж хугацаанд нь ирүүлээгүй болон өмнөх оны агаарын бохирдлын төлбөрийн өртэй аж ахуйн нэгж, байгууллагыг агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлөхгүй, хөнгөлөлт үзүүлэхгүй.

2.5. Агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлөх болон хөнгөлөлт үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг энэхүү журмын 1.2, 1.3-т нийцүүлэн жил бүр хянан шинэчилж болно.

Гурав. Хариуцлага

3.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- оОо -----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар
хот

Тэмдэглэлт өдрийн тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Энхийг сахиулагчдын олон улсын өдөр буюу 5 дугаар сарын 29-ний өдрийг Монгол Улсад “Энхийг сахиулагчдын өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтооюур баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-д “4.1.48.Энхийг сахиулагчдын өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 29-ний өдөр” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

Ж.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлгагнах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.



2. Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлагнах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт даалгасугай.

3. Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлагнах журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай.

4. Засгийн газрын 2008 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн ёслолын журам”-ын 18.1-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд бэлэг дурсгалын зүйл хүлээн авах, өгөх асуудлыг “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор баталсан журам болон “Зардлын норматив, журам батлах тухай” Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 198 дугаар тогтоолын дагуу тус тус шийдвэрлэж байна.”

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ын “Бэлэг, дурсгалын зүйл хүлээн авах, тайлагнах, зарцуулах” гэсэн Гуравдугаар бүлгийг, мөн журмын Дөрөвдүгээр бүлгийн 16 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР



Засгийн газрын 2012 оны 141 дүгээр
тогтоолын хавсралт

АЛБАН ТУШААЛТАН ДИПЛОМАТ ЖУРМААР БЭЛЭГ АВАХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлгийг мэдүүлэх, зарцуулах, тайлагнахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг буцаан хэрэглэхгүй бөгөөд Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хүчин төгөлдөр болсон өдөр буюу 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

1.3. Албан тушаалтны гэр бүлийн гишүүнд дипломат журмаар өгсөн бэлэг энэхүү журмын зохицуулалтад нэгэн адил хамаарна.

1.4. Энэхүү журамд өөрөөр заагаагүй бол албан тушаалтанд дипломат журмаар өгсөн бэлэг (цаашид “бэлэг” гэх)-ийг төрийн мэдэлд шилжүүлнэ.

1.5. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “албан тушаалтан” гэж Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1-д заасан албан тушаалтныг;

1.5.2. “дипломат журам” гэдэгт Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой дор дурдсан үйл ажиллагааг хамааруулна:

а) Засгийн газраас баталсан “Төрийн ёслолын журам”-д заасан дипломат ёслолын арга хэмжээ;

б) дипломат ёслолын арга хэмжээнээс бусад



Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой арга хэмжээнд албан тушаалтан өөрт олгогдсон бүрэн эрхийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, хуулийн этгээдтэй албаны журмаар харилцах үйл ажиллагаа.

Хоёр. Бэлэг авах, мэдүүлэх

2.1. Дипломат ёслолын арга хэмжээнээс бусад арга хэмжээний үед дипломат журмаар өгсөн бэлгийг албан тушаалтан биечлэн авна.

2.2. Монгол Улс болон гадаад улсад зохион байгуулсан дипломат ёслолын арга хэмжээний үеэр албан тушаалтандаа өгсөн бэлгийг тухайн арга хэмжээний Монголын талын ёслол хариуцсан ажилтан хүлээн авч, бэлэгний бүрэн бүтэн байдал, хадгалалтыг хариуцна.

2.3. Энэхүү журмын 2.1-д заасны дагуу авсан бэлгийг албан тушаалтан бэлэг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор байгууллагынхаа Тамгын газар (захиргааны хэлтэс)-т мэдүүлнэ. Албан тушаалтан гадаад улсад байхдаа авсан бэлгийг Монгол Улсад хүрэлцэн ирснээс хойш ажлын 7 хоногийн дотор мэдүүлнэ.

2.4. Бэлэг хүлээн авсан тухай мэдүүлэг (цаашид “мэдүүлэг” гэх)-ийг энэхүү журмын хавсралтаар баталсан маягтын дагуу гаргана.

2.5. Тухайн байгууллагын Тамгын газар (захиргааны хэлтэс) нь албан тушаалтны мэдүүлэг болон бэлгийг хүлээн авч, энэхүү журмын 3.1-д заасан Комисс (цаашид “Комисс” гэх)-т ажлын 7 хоногийн дотор шилжүүлнэ.

2.6. Дипломат ёслолын арга хэмжээний үеэр гардуулсан бэлэгний мэдүүлгийг албан тушаалтны нэрийн өмнөөс ёслол хариуцсан ажилтан энэхүү журмын 2.3, 2.4-т заасан хугацаанд гаргаж бэлэгний хамт Комисст хүлээлгэн өгнө.

2.7. Мэдүүлэгт бэлгийг хавсаргах боломжгүй бол түүний шалтгааныг дурдаж, бэлэг байгаа газрыг заана.

2.8. Мэдүүлэгт дараах мэдээллийг тусгана:



2.8.1. бэлэг хүлээн авсан албан тушаалтны ургийн овог, овог, нэр, албан тушаал, гэр бүлийн гишүүн нь бэлэг авсан бол түүний ургийн овог, овог, нэр, ажил, албан тушаал, эхнэр, нөхөр, хүүхдийн аль нь болох;

2.8.2. бэлэгний тодорхойлолт;

2.8.3. бэлэг хүлээн авсан газар болон огноо;

2.8.4. бэлэгний үнэ;

2.8.5. бэлэг хүлээн авах болсон үндэслэл, шалтгаан;

2.8.6. бэлэг өгсөн хүний овог, нэр, албан тушаал, эсхүл хуулийн этгээдийн нэр, хэрэв бэлэг өгсөн этгээд тодорхойгүй бол мэдүүлэгт энэ тухай зааж өгнө;

2.8.7. бэлгийг өөртөө үлдээх талаар албан тушаалтны гаргасан санал.

Гурав. Комисс, түүний бүрэн эрх

3.1. Мэдүүлгийг хүлээн авч бүртгэн, үнэлэх, зарцуулах асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий Комиссыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

3.2. Комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гурваас доошгүй гишүүнтэй байна.

3.3. Комиссыг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төрийн дипломат ёслол хариуцсан нэгжийн дарга ахална.

3.4. Комисс асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл хөтөлнө.

3.5. Комиссын ажиллах журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дөрөв. Мэдүүлгийг бүртгэх

4.1. Комиссын нарийн бичгийн дарга ирүүлсэн мэдүүлгийн талаар бүртгэл (цаашид “бүртгэл” гэх) хөтөлнө.

4.2. Бүртгэлд дараахь мэдээллийг тусгана:

- 4.2.1. мэдүүлэг хүлээн авсан огноо;
- 4.2.2. бүртгэлийн дугаар;
- 4.2.3. бэлэгний төрөл;
- 4.2.4. бэлэг өгсөн талын талаархи мэдээлэл;
- 4.2.5. бэлэг хүлээн авсан албан тушаалтны талаархи мэдээлэл.

Тав. Бэлгийг үнэлэх

5.1. Комисс мэдүүлгийг хянаж, бэлэгний үнийг тогтооно.

5.2. Комисс бэлгийг тухайн үеийн зах зээлийн ханшийг баримтлан үнэлнэ.

5.3. Шаардлагатай бол Комиссын шийдвэрээр бэлэгний үнийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу мэргэжлийн үнэлгээчнээр тогтоолгож болно.

5.4. Комисс тухайн бэлэг нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарч болзошгүй гэж үзсэн тохиолдолд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөлд хандаж дүгнэлт гаргуулна.

5.5. Мэргэжлийн зөвлөл нь бэлгийг түүх, соёлын дурсгалт зүйлд хамааруулах тухай дүгнэлт гаргасан тохиолдолд тухайн бэлгийг эзэмшилд нь өгөх холбогдох соёлын байгууллагыг Комисст санал болгоно.

Зургаа. Бэлэг зарцуулах

6.1. Комисс бэлгийг зарцуулах талаар дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:



6.1.1. бэлэг хүлээн авсан албан тушаалтан бэлгийг өөртөө үлдээх хүсэлт гаргасан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага, эсхүл түүнтэй тэнцүү хэмжээний үнийн дүнтэй бэлгийг үнэ төлбөргүй, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүү үнэ бүхий бэлэгний үнийн зөрүүг төлүүлсний үндсэн дээр тухайн албан тушаалтны өмчлөлд шилжүүлэх;

6.1.2. мэдүүлэг гаргасан албан тушаалтны ажилладаг буюу харьяа байгууллагын хэрэгцээнд үнэ төлбөргүй шилжүүлэх;

6.1.3. төрийн болон нутгийн захиргааны бусад байгууллагын хэрэгцээнд үнэ төлбөргүй шилжүүлэх;

6.1.4. түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах бэлгийг энэ журмын 5.5-д заасны дагуу холбогдох соёлын байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлэх;

6.1.5. дуудлага худалдаагаар борлуулах.

6.2. Энэ журмын 6.1.4-т заасан соёлын байгууллага тухайн бэлгийг авахаас татгалзсан тохиолдолд Комисс мөн журмын 6.1.2, 6.1.3, 6.1.5-д заасны дагуу зарцуулахаар шийдвэрлэнэ.

6.3. Хадгалалтын хугацаа дууссан, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон, холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор хөнөөлтэй болох нь тогтоогдсон зэрэг шалтгааны улмаас бэлгийг захиран зарцуулах, ашиглах боломжгүй гэж Комисс үзсэн тохиолдолд түүнийг баримт үйлдэн устгаж болно.

6.4. Комисс шийдвэрт тухайн бэлгийг зарцуулах, эсхүл устгах үндэслэлийг тодорхой зааж, бүртгэлд энэ талаар тэмдэглэл хийнэ.

6.5. Энэхүү журмын 6.1.5-д заасан дуудлага худалдааг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан журмыг баримтлан зохион байгуулж орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.



**Долоо. Мэдүүлэг гаргасан албан тушаалтны
өмчлөлд бэлэг шилжүүлэх**

7.1. Мэдүүлэг гаргасан албан тушаалтан бэлгийг өөртөө үлдээх санал гаргаж болно. Мэдүүлэгт энэ тухай тусгана.

7.2. Комиссоос тогтоосон бэлэгний үнэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүү байгаа тохиолдолд албан тушаалтан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтэрсэн үнийн зөрүүг төлнө.

7.3. Албан тушаалтан бэлэгний үнийн зөрүүг төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нээсэн Төрийн сангийн зохих дансанд тушаана.

7.4. Бэлэгний үнийн зөрүүг төлсөн баримтыг үндэслэн Комисс бэлгийг санал гаргасан албан тушаалтанд шилжүүлж энэ тухай бүртгэлд тэмдэглэл хийнэ.

7.5. Энэхүү журмын 7.1-7.4 дэх заалт түүх, соёлын дурсгалт зүйл гэж тодорхойлсон бэлэгт хамаарахгүй.

Найм. Тайлагнах

8.1. Комисс бэлэгний бүртгэл, зарцуулалтын талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хагас жил тутам тайлан гаргаж өгнө.

8.2. Энэхүү журмын 8.1-д заасан тайлан нь нийтэд нээлттэй байх бөгөөд Комисс түүнийг цахим хуудас болон бусад хэлбэрээр нийтэд ил тод мэдээлнэ.

Ес. Маргаан шийдвэрлэх

9.1. Бэлгийг үнэлэх, зарцуулах асуудлаар Комиссын гаргасан шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргана.

9.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын



гишүүн гомдлыг 30 хоногийн дотор шийдвэрлэж хариуг бичгээр өгнө. Уг хугацаанд хариу өгөөгүй, эсхүл хариуг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

9.3. Энэхүү журмын 9.1, 9.2-т заасны дагуу гомдол гаргасан тохиолдолд тухайн гомдлыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд бэлгийг зарцуулах талаар Комиссын гаргасан шийдвэрийг түдгэлзүүлнэ.

Журмын хавсралт

ДИПЛОМАТ ЖУРМААР БЭЛЭГ ХҮЛЭЭН
АВСАН ТУХАЙ МЭДҮҮЛЭГ

Мэдүүлэг гаргагчийн бөглөх хэсэг

Миний бие дипломат журмаар бэлэг хүлээн авснаа үүгээр мэдүүлж байна.

_____ (гарын үсэг) _____ (огноо)

1. Мэдүүлэг гаргагчийн: Ургийн овог _____ Овог _____

Нэр _____ Байгууллага, албан тушаал _____

2. Бэлгийг өөрөө хүлээн авсан Гэр бүлийн гишүүн хүлээн авсан

Гэр бүлийн гишүүн хүлээн авсан бол: Ургийн овог _____

Овог _____ Нэр _____

Ажил албан тушаал _____

Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн ямар гишүүн болох _____

3. Мэдүүлэгт бэлгийг хавсаргасан хавсаргаагүй

Хавсаргаагүй бол шалтгаан: _____

Байршил: _____

4. Бэлэгний тодорхойлолт: _____



5. Бэлэг хүлээн авсан газар: _____ огноо: _____

6. Бэлэгний үнэ: _____ тодорхойгүй

7. Бэлэг хүлээн авах болсон үндэслэл, шалтгаан: _____

8. Бэлэг өгсөн хувь хүн хуулийн этгээд тодорхойгүй

Хувь хүний овог, нэр, эсвэл хуулийн этгээдийн нэр: _____

Албан тушаал, хуулийн этгээд бол хаяг: _____

9. Мэдүүлгийг хугацаанд нь гаргасан хугацаа хожимдуулсан

Хожимдуулсан бол шалтгаан _____

10. Бэлгийг өөртөө үлдээх санал гаргаж байгаа үгүй

Гарын үсэг _____

Холбогдох байгууллагын асуудал
хариуцсан ажилтны бөглөх хэсэг

1. Мэдүүлэг хүлээн авсан газар _____ огноо: _____

2. Хүлээн авсан ажилтны нэр: _____ албан тушаал: _____

_____ (гарын үсэг)

3. Мэдүүлэг, бэлэг хамт хүлээж авсан зөвхөн мэдүүлэг авсан

4. Бэлэг бүрэн бүтэн гэмтэлтэй тодорхойгүй

Бүрэн бүтэн биш бол тодорхойлж бичих, тодорхойгүй бол
шалтгааныг бичих _____

Комиссын бөглөх хэсэг

1. Мэдүүлэг хүлээн авсан газар: _____ огноо: _____

2. Хүлээн авсан ажилтны нэр: _____ албан тушаал: _____
_____ (гарын үсэг)3. Мэдүүлэг, бэлэг хамт хүлээж авсан зөвхөн мэдүүлэг авсан

4. Бэлэгний үнэ _____ (тоогоор) _____ (үсгээр)

5. Бэлэг урлаг, өв соёл, түүхийн үнэ цэнэтэй үгүй

6. Комиссын шийдвэр

6.1. Албан тушаалтны өмчлөлд шилжүүлэх (журмын 6.1.1) 6.2. Харьяалах байгууллагын хэрэгцээнд шилжүүлэх (журмын 6.1.2) 6.3. Өөр байгууллагын хэрэгцээнд шилжүүлэх (журмын 6.1.3) 6.4. Соёлын байгууллагад шилжүүлэх (журмын 6.1.4) 6.5. Дуудлага худалдаагаар борлуулах (журмын 6.1.5) 6.6. Устгах (журмын 6.3) Комиссын шийдвэрээр бэлгийг шилжүүлэн
авсан албан тушаалтны бөглөх хэсэг

1. Бэлэг хүлээн авсан газар: _____ огноо: _____

2. Хүлээн авсан ажилтны нэр: _____ албан тушаал: _____
_____ (гарын үсэг)



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар
хот

Говийн бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тавантолгой, Оюутолгой орчмын газар нутагт байгаль орчны үнэлгээ хийлгэх ажлыг эрчимжүүлж, тухайн бус нутгийн малчдын өвөлжөө, хаваржаа уул уурхайн эдэлбэр газартай давхардсан тохиолдолд нөхөн олговор олгох асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа нарт даалгасугай.

2. Дараахь асуудлаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай:

2.1. Түүхий нүүрс, төмрийн хүдэрт экспортын татвар ногдуулах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх;

2.2. “Замын-Үүд” хилийн боомтын ачааны автомашин шалган нэвтрүүлэх цогцолбор, зам талбайн өргөтгөлийн ажил болон уг цогцолбороос гаалийн рентген хяналтын талбай хүртэлх 2.3 км хатуу хүчилттай авто замыг 2012 оны эхний хагас жилд багтаан ашиглалтад оруулах арга хэмжээ авах.

3. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах бүтцийн талаар тодорхой санал боловсруулж, энэ оны 5 дугаар сард багтаан Засгийн газарт оруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

4. “Замын-Үүд” боомтод үүсч байгаа авто тээврийн



хэрэгслийн бөөгнөрлийг багасгах зорилгоор хилийн хяналт шалгалт явуулах талбайг өргөтгөж, ачааны автомашины шалган нэвтрүүлэх цогцолбороос БНХАУ-ын Эрээний боомт хүртэл 1 км, мөн тус цогцолбороос төмөр замын шилжүүлэн ачих III терминал хүртэл 8 км хатуу хучилттай авто замыг барих хөрөнгийн асуудлыг 2012 оны эхний хагас жилд багтаан зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч Д.Мандах тус тус даалгасугай.

5. Хот суурин, орон нутгийн ажилгүй иргэдийг бүртгэж, уул уурхай, аж үйлдвэрийн салбарт шаардлагатай мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах, уул уурхайн болон шинээр байгуулж байгаа үйлдвэрүүдэд ажиллах монгол ажилчдыг ажлын байраар хангах зорилгоор Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд зохион байгуулалттайгаар элсүүлэн сургах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Огтонбаяр, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар
хот

**Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
үндэсний стратеги батлах тухай**

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.3 дахь заалт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2010 оны 64/255 тогтоолыг хэрэгжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний

стратеги (2012-2020 он)-ийг 1 дүгээр хавсралт, стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Стратегийг хэрэгжүүлэхдэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгахын зэрэгцээ гадаад, дотоодын болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын тусlamж, зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Огтонбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Стратеги, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг өөрийн эрхэлсэн ажлын хүрээ, харьяа нутаг, дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан ажиллахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдоржид үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.ДАШДОРЖ

Засгийн газрын 2012 оны 146 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ (2012-2020 ОН)**

Нэг. Үндэслэл, шаардлага

Дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1.2 сая гаруй хүн амь насаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн



хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна. Зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас бааралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжих байгаа улс оронд ногдож, жилд нийт 65 тэрбум ам. долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд Ерөнхий Ассемблейн хуралдаанаас 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас бааралтыг 50 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

2010 онд Тайланд Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссын Бүс нутгийн замын хөдөлгөөний шинжээч нарын уулзалтаар улс орон бүрт зам тээврийн ослын нас бааралтыг бууруулах “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж”-ийг гаргасан болно.

Манай улсын хувьд зам тээврийн осол, зөрчлийн тоо жилээс жилд нэмэгдэж, түүнээс шалтгаалах нас бааралт өсөх хандлагатай байна¹. Манай улсад гарч байгаа нийт осол, гэмтлийн 18.9 хувийг зам тээврийн осол эзэлж байна².

Зам тээврийн осолд өртөх, гэмтэх явдал их байгааг албан ёсны статистикийн мэдээ, хүн амын дунд хийсэн судалгаа харуулж байна. Тухайлбал³, 15-64 насны иргэдийн 4 хувь нь сүүлийн 12 сарын дотор зам тээврийн осолд өртсөн байна. Зам тээврийн осол, гэмтэл үүсэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь хурд хэтрүүлэх (22.7 хувь), согтууруулах ундаа хэрэглэх (9.1 хувь) зөрчил болж байгаагаас гадна хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангахгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын биелэлт хангалтгүй, тээврийн хэрэгслийн парк хэт хуучирсан, хөдөлгөөнд оролцогчдын соёл, боловсрол дутмаг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг дутагдлууд байгаа нь судалгаагаар тогтоогдсон болно. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

¹Çàì öyýâðèéí î ïï ë, ãï öyë, özëj úyñ ñýðâðèéóò ì yáyýééééí áåäö. 2010, i ï ÑÑ.

²Yðzjzj ì yí äééí ñðâðèñðèéééí zçzçééýéòzjzj. 2008 i í, YÍ Á

³ÓÁ ì Á-ééí ø àéððääí , ýðñäýéóò õzééí çzééñééí òàðððæðñí ñóääéäà. 2009, õóóääñ 86-89.

явдал нь замын хөдөлгөөнийг зохицуулагч, жолоочийн үүрэг мэт алдаатай ойлголт байсан бөгөөд орчин үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн харилцан уялдаа бүхий цогц асуудал гэдгийг эрдэмтэд тогтоогоод байна.

Хоёр. Стратегийн алсын хараа буюу хэтийн зорилго

2.1. Салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг ханган “Хүн-Тээврийн Хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн системийн аюулгүй байдлыг цогцоор нь бүрдүүлэх замаар зам тээврийн ослын сөрөг үр дагаварыг мэдэгдэхүйц хэмжээгээр багасгана.

Гурав. Стратегийн зорилт

3.1. Монгол Улсын хэмжээнд 2012-2020 онд зам тээврийн ослын улмаас нас барсан болон хүнд гэмтсэн хүний тоог тус бүр 50 хувиар бууруулна.

Дөрөв. Стратегийн гол зорилтууд

4.1. Хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент.

4.2. Аюулгүй зам, орчин.

4.3. Аюулгүй тээврийн хэрэгсэл.

4.4. Хөдөлгөөнд оролцогчдод зориулсан үйл ажиллагаа.

4.5. Ослын дараах тусламж, үйлчилгээ.

Тав. Гол зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах
үйл ажиллагааны чиглэл

5.1. Хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент:

5.1.1. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх;

5.1.2. мэргэжлийн хүний нөөцийг тусгайлан бэлтгэх;

5.1.3. эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох;

5.1.4. хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийг



үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах байгууллагыг бий болгон, холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлагыг оновчтой, зөв тодорхойлох;

5.1.5. үндэсний хэмжээний стратеги хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох;

5.1.6. авто тээврийн салбарын даатгалын системийг боловсронгуй болгох;

5.1.7. судалгаа, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох;

5.1.8. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цогц байдлаар судлах судалгаа шинжилгээний бие даасан, хараат бус албыг бий болгох;

5.1.9. замын хөдөлгөөнд тавих хяналтын тогтолцоог дараахь байдлаар ангилан тодорхойлно:

а) замын хөдөлгөөний хяналт (Замын хөдөлгөөний зохицуулалт, зохион байгуулалт, тэмдэг, тэмдэглэл, жолоочийн бүртгэлийн, тээврийн хэрэгсэлд тавих хяналт);

б) замын хөдөлгөөнд оролцогчдод тавих хяналт (Замын хөдөлгөөнд оролцогчдын хөдөлгөөний хяналт, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа) гэж.

5.2. Аюулгүй зам, орчин:

5.2.1. авто замын сүлжээний аюулгүй байдлыг нийт хөдөлгөөнд оролцогчид, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон явган, дугуйгаар зорчигчдод зориулан сайжруулах;

5.2.2. хот төлөвлөлтийн хууль тогтоомж, ерөнхий төлөвлөгөөг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог бий болгох;

5.2.3. хотын блок хоорондын зайд 150 метрээс ихгүй байхаар төлөвлөх;

5.2.4. хотын төвийн хөдөлгөөний ачааллыг “хэрэглэгч төлдөг” зарчимд шилжүүлэх замаар багасгах;

5.2.5. замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед орчин үеийн техник технологи, стандартыг хэрэглэж аюулгүй байдлын шаардлагыг заавал хангах;



5.2.6. хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийдэг байх;

5.2.7. замын сүлжээний төлөвлөлтийг зорчигч болон ачаа тээврийн төлөвлөлттэй нягт уялдуулах.

5.3. Аюулгүй тээврийн хэрэгсэл:

5.3.1. дэлхий нийтээр мөрдөж байгаа стандарт, шаардлага, орчин үеийн технологид нийцүүлэн авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх;

5.3.2. тээврийн хэрэгслийг импортоор оруулах асуудлаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

5.3.3. тээврийн хэрэгсэл, түүний эд ангийг дотоодод үйлдвэрлэх, угсрехад тавигдах техникийн шаардлага, стандартыг боловсруулан мөрдөх;

5.3.4. тээврийн хэрэгслийн ашиглалт буюу засвар үйлчилгээний бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

5.3.5. авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийн санг бий болгох замаар “Үйлчилгээ-Оношилгоо-Хяналтын” нэгдсэн системийг бүрдүүлэх.

5.4. Хөдөлгөөнд оролцогчдод зориулсан үйл ажиллагаа:

5.4.1. замын хөдөлгөөнд аюулгүй оролцох мэдлэг боловсрол иргэдэд олгох ажлыг боловсролын тогтолцооны бүх шатанд нэвтрүүлэх;

5.4.2. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад олон нийтийн мэдлэг, соёл, ухамсыг дээшлүүлэх, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах ажлыг хүртээмжтэй зохион байгуулах;

5.4.3. замын аюулгүй байдлын талаархи хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох замаар хөдөлгөөнд оролцогчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх;

5.4.4. хурд хэтрүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодох, хамгаалах бүс, малгай хэрэглэхгүй байгаа зөрчлийг онцгойлон анхаарч, урьдчилан сэргийлэх;

5.4.5. жолооч бэлтгэх, мэргэшүүлэх, шалгалт авах, үнэмлэх олгох тогтолцоог боловсронгуй болгох.

5.5. Ослын дараах тусламж, үйлчилгээ:



5.5.1. ослын үед гэмтсэн хүнд үзүүлэх яаралтай тусlamж, нөхөн сэргээх эмчилгээ болон бусад үйлчилгээний чанарыг сайжруулах;

5.5.2. анхны тусlamж үзүүлэх мэдлэг чадварыг иргэдэд эзэмшүүлэх;

5.5.3. гэмтсэн хүнд цаг алдалгүй тусlamж үзүүлэх даатгалын систем болон осол, гэмтлийг тандах системийг бий болгох;

5.5.4. авто замын сүлжээн дэх эмнэлгийн тусlamж үзүүлэх цэгүүдийн тоог нэмэгдүүлж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах;

5.5.5. жолооч нарын эмнэлгийн үзлэгийн бүртгэлийг жолоочийн бүртгэлийн системтэй холбох замаар тэднийг эмнэлгийн үзлэгт заавал хамруулах нөхцөлийг бүрдүүлэх.

Зургаа. Стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах

6.1. Стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгур үзүүлэлтийн дагуу үнэлэх ажлыг зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.

6.2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн түвшинд удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайллагнах ажлыг бүх шатны Засаг дарга мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

6.3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, нийслэл, сум, суурин газрын ерөнхий төлөвлөгөө болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Долоо. Санхүүгийн эх үүсвэр

7.1. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.1.2. зээл, тусlamж, төслийн санхүүжилт;

7.1.3. байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусlamж;

7.1.4. бусад эх үүсвэр.

Найм. Стратегийн үр дүн, хяналт, үнэлгээ

8.1. Стратегийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

8.1.1. улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын чадавхи дээшилж, зам тээврийн ослын тоог багасгах, түүнээс удьцилан сэргийлэх, тусlamж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна;

8.1.2. зам тээврийн осол, гэмтлээс сэргийлэх орчин тодорхой хэмжээнд бүрдэнэ;

8.1.3. зам тээврийн осолд өртсөн иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, тухайн мэргэжлийн хүний нөөцийн чадавхи сайжирна;

8.1.4. зам тээврийн ослын улмаас учрах хүний амь нас, эрүүл мэнд, эд материалын хохирлын хэмжээ мэдэгдэхүйц хэмжээгээр буурна;

8.1.5. зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага стратегийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газарт жил бүр танилцуулна;

8.1.6. орон нутагт бүх шатны Засаг дарга стратегийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайлагнана.

Ес. Стратегийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

9.1. Стратегийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:



Шалтуур үзүүлэлт	2012 оны сурь түвшин	2015 онд хүрэх түвшин	2020 онд хүрэх түвшин
Зам тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол (10.000 тээврийн хэрэгсэлд нөлдох)	17.5	13.1	8.8
Зам тээврийн ослын улмаас хунд гэмтсэн хүний тоо (10.000 тээврийн хэрэгсэлд нөлдох)	48.1	36.0	24.0
Явган зорчигчийн буруутайн улмаас гарсан осол хэргийн хувь	17.0	12.7	8.5
Замын хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан хатуу хүчинлтийн авто замын урт (км)	2244 км	5000 км	10000 км
Улсын чанартай хатуу хүчинлтийн замын урсгал засвар, арчалтын ажлыг тогтолц болгож зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, ашиглалтын бэлэн байдлыг хангах болон жил бүр 200 км замд ээлжит засвар хийх хөрөнгийн хэмжээ (төг)	9.000 сая төгрөг	40.000 сая төгрөгөөс доошгүй	60.000 сая төгрөгөөс доошгүй
Зам, замын байгууламжийн засвар, арчалтын ажлыг хариуцан хяналт тавьж ажиллах байгууллагын тоо	21 км	200 км тутамд	150 км тутамд



Шинээр төлөвлөсөн болон баригдсан аюулгүйн гарц, гармын тоо	2	6	12
Шинээр барьж байгуулах авто замын төсөлд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэхэд хөндлөнтийн аудитын дүгнэлт гарган Үнэлгээ хийсэн тоо	350 км 2500 км 5000 км		
Соттууруулахчадаа хэрэглэн тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил (хувь) Хот Хөдөө	7.5 27.1	5.0 20.0	3.0 13.0
Салбарын хэмжээнд ажиллаж байгаа аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн хүний тоо	18	50	400
Хамгаалах хэрэгсэл ашиглаж байгаа хувь: -Хамгаалах бус -Хамгаалах малгай -Хүүхдийн сундал	13.5 7.1 0.0	90 90 90	100 100 100



Осол, гэмтэлд өртөгдөд анхны тусламж үзүүлэх талаар сургалтад хамрагдсан хүний тоо	1957	40000	80000
Согтолтын зэрэг, хурд хэмжих тохог төхөөрөмжийн хангалт (ширхэг)	6	89	100
Явган болон унадаг дугуйгаар зорчигчид зориулсан замын урт (км)	2450	2700	3000
Техникийн хяналт, оношилгооны станцын тоо	23	28	35
Тээврийн хэрэгслийн дундаж насжилт (жил)	11.2	10	9
Зүүн гар талдаа жолооны хурдтай тээврийн хэрэгсэл (хувь)	54.0	75.0	95.0
Ослын үед ирэх тусламжийг хүлээх дундаж хугацаа (минут)	30	20	15
Осол, гэмтлийн тандалтын тогтолцооны хэрэгжилт (хувь)	62	85	95-98
Улаанбаатар хотын төвийн хөдөлгөөний дундаж хурд (км/цаг)	12	30	45

Засгийн газрын 2012 оны 146 дугаар
тотоолын 2 дугаар хавсралт

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ (2012-2020 ОН)-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ДЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Булаг 1. Хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн чиглэээр				
1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний стратегийн хэрэгжүүлэх дунд болон бодино хугацааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	ЭМЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарын Тамгын газар	2012-2013
2	Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гадаад орны төргүүний туршилагад тулгуурлан боловсруулан хэрэгжүүлж эхлэх	ЗТБХБЯ	ЭМЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарын Тамгын газар	2012
3	Холбогдох байгуулгын хариуцах ажил, Ургийг нарийвулан тодорхойлж, хэрэгжилтийг зөхицуулан зохион байгуулах Үндэсний хороо байгуулах	ЗТБХБЯ	ЭМЯ, ХЗДХЯ	2013-2014
4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэргэжилтэн, ажилтан нарыг тусгайлан бэлтгэх	БСШУЯ	ЗТБХБЯ, ХЗДХЯ	2012-2020
5	Авто тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын 10 хувийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зориулан ашиглах	СЯ, ЗТБХБЯ	ЭМЯ, ХЗДХЯ, БСШУЯ	2012-2020



6	Улсын хэмжээнд замын хөдөлгөөний агуулж байдлыг хууль тогтоомжийг мэдээлийн программ хянгамж, тоног төхөөрөмж бүхий хянчалтын нэгдсэн тогтолцоо бий болгох	Замын хөдөлгөөний хангахтай мөрдүүлэхэд ашиглах	ЗТБХБЯ, ХЗДХЯ	ЭМЯ	2012-2013
7	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг олон Улсын жишигт нийцүүлж, дурэм, стандартыг боловсронгуй болгон шинэчлэн батлуулах	ЗТБХБЯ	ХЗДХЯ	ХЗДХЯ	2012-2015
8	Замын хөдөлгөөнд тавих хяналтын уург, хариуцлагыг салбар тус бүрээр тодорхой болгох, хянчалтын эрх зүйн орчинг бурдуулэх	ЗТБХБЯ, ХЗДХЯ	МХЕГ	МХЕГ	2012-2015
9	Нийт авто замын служжэний 70 хувьд орчин учийн техник хэрэгслээд ашиглан замын хөдөлгөөнд хяналт тавих	ЗТБХБЯ	СЯ, ХЗДХЯ	СЯ, ХЗДХЯ	2015-2020
10	Замын хөдөлгөөний зохицуулагч нарыг жолбоочийн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэлэсэн эсэхийг тогтоох болон хурд хэмжих багажаар хангах	ХЗДХЯ	СЯ	СЯ	2012-2015
11	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрийн объектив, субъектив шалтгаан нөхцөлийг нарийчлан тогтоох чиглэлээр салбарын мэргэжилтийг бэлтгэх, Мөртешүүлэх, давтан сургах	БСШУЯ, ЗТБХБЯ, ХЗДХЯ	СЯ	СЯ	2012-2020
12	Зам тээврийн осол харийг шинжлэн шалгах, шалтгаан нөхцөлийг нарийчлан судлах бие даасан байгууллага бий болгох	ЗТБХБЯ, ХЗДХЯ	СЯ	СЯ	2012-2015



Бүлэг 2. Аюулгүй зам, орчныг сайжруулах чиглэээр

Олон улсын болон улсын чанартай хатуу хүчилттэй автомамын тоог 2 дахин намэгдүүлж, замын Тэмдэг, Тэмдэгэл, гэрэлтуулэг, хашлата, гармыг оновчтой байрлуулах	3ТБХБЯ	ХэзДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дэргүүн Тамгын газар	2012-2016
Авто замын байгууламжийг төлөвлөх, зураг төсөл зохиох, түүний барих, ашиглах, арчлахад аюулгүй байдлын үнэлгээ завал хийж, замын аюултай хэсгийг тогтоон засаж сайжруулах	3ТБХБЯ	ХэзДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дэргүүн Тамгын газар	2012-2020
Авто замын засвар, арчлалтын менежментийг боловсронгуй болгох, жилд 200 км замд ээлжжит засвар хийх	3ТБХБЯ	ХэзДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дэргүүн Тамгын газар	2012-2020
Авто замын судалгаа шинжилгээний хүрээлэн байгуулж, гадаад орны дэвшүүлэлт техник, Технологийг судалж нутагшуулах	3ТБХБЯ	A3Г	2012-2020
Жил тутам авто замын инженер, техник Мөргэжлээр 50-иас доошгүй хүнийг дотоодод бэлтгэх, 250-иас доошгүй мөрэжилтэй ажилчин бэлтгээдэг болох	3ТБХБЯ	БСШУЯ	2012-2016
Замын барилгын ажлын хяналтыг зөвлөх үйлчилгээний бие даасан компаниар	3ТБХБЯ	СЯ	2012-2016



19	Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө, холбогдох хувьт тогтоомжийг боловсронгуй болгох	ЗТБХБЯ	ХЗДХЯ	2012-2015
20	Хот төлөвлөхдөө блок хоорондын зайд 150-200 метрээс ихгүй байхаар зохион байгуулах	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2015
21	Хотын төвийн хөдөлгөөний ачааллыг “хэрэглэгч төлдөг” зарчимд шилжүүлэх замаар багасгах	ЗТБХБЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2014
22	Томоохон хотуудад явсан зорчилийн аюулгүйн гармын тоог нэмэгдүүлэх, тухайлбал явган зорчигчид зориулсан гарам, хонгил, гүүрэн гарц байгуулж, гэрлэн дохионы горимыг сайдруулах	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
23	Хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн даац, хэмжээг олон улсын конвенцийн шаардлагад нийцүүлэх, уурхайн буюутусгай зориулалтын авто замын станцарт, техникийн нөхцөлийг тогтоон, хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2013
24	Хөдөлгөөнд оролцож хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, енцер настан, явтан зорчигч, моторт бус тээврийн хэрэгслээр болон мотоциклоор зорчигчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авто замын хийцэд тусган төрөвлөж, хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020

25	Тусгааралтны нэмэгдүүлж, хотын болон хот орчмын бүсэд явган зорчигч, унадаг дугуйгаар зорчигч, мотоциклоор зорчигч нарт зориулсан зэм, аюулгүй бүс бий болгох (боломжтой хэсэгт)	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг Даргын Тамгын газар	2012-2020
26	Хот хоорондын болон хотын тээврийн сүржээ, Улчилгээг нэгдсэн байдлаар хөгжүүлэх, тээврийн төрөл хорондын (авто тээвэр, темер зам, агаарын тээвэр) уялдааг хангах, хот хоорондын болон хотын доторхи замын хөдөлгөөнийг тусгаарлах (хот хоорондын тээврийг хотын захаар тойруулах)	ЗТБХБЯ	Нийслэлийн нийтийн йн тээврийн газар	2012-2020
27	Хотын хөгжлийг дэмжих, ерсөндөх чадвар бүхий нийтийн тээврийн тогтолцоог бурдудэх, ингэхдээ их багтаамжийн тээврийн төрлийн системийг бий болгон автобус, микро автобус, такси үйлчилгээг уялдуулах	Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар,	Нийслэлийн нийтийн тээврийн газар	2012-2015
28	Замын хөдөлгөөнийг хангах, ялангуяа хотын төв, түүжрэлтэй байрлалтуудад автомашины хэрэглээг хянан зохицуулах	Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар,	Нийслэлийн нийтийн тээврийн газар, Замын цагдаагийн газар	2012-2015
29	Замын хөдөлгөөний хянантын тогтолцоог нийт замын урт болон тээврийн хэрэгслийн тоонд зохистойгоор уялдуулах	ЗТБХБЯ	ХЗДХЯ	2012-2020



Бүлэг 3. Аюулгүй тээврийн хэрэгсэл ашиглах талаар						
	Тээврийн хэрэгслийг шинээр угтрах, зүйн эрх шаардлагах зохицуулалтыг бий болгох	ЗАСГИЙН ГАЗАР	Засаг дарын Тамтын газар	Аймаг, нийслэлийн газар	Аймаг, нийслэлийн газар	ЖИЛ БҮР
30	Тээврийн хэрэгсэлд тавигдах олон улсын стандартыг стандартыг стандарт болгон шаардлагыг нь бураэн хангуулах талаар арга хэмжээ авах	ЗТБХБЯ	ЗТБХБЯ	СХЭГ	СХЭГ	ЖИЛ БҮР
31	Монгол Улсын хэмжээнд ашигладж байгаа тээврийн хэрэгслийн паркийг дараах зарчмаар шинэчлэх: а) Тээврийн хэрэгслийг импортоор оруулах асуудлаархи бодлопыг шинэчлэн болсовсруулж, 6-гаас дээш жил ашигладсан тээврийн хэрэгслийг импортоор оруулахыг хязгаарлах; б) Монгол Улсын хэмжээнд ашигладж байгаа нийт тээврийн хэрэгслийг зүйн гар талдаа жолдооны хурдтай болгох;	ЗТБХБЯ	ЗТБХБЯ	СЯ	СЯ	2012-2015
32	В) Тээврийн хэрэгслийн сэлбэгийг импортоор оруулах бодлогыг өөрчилж, шинэ сэлбэгийг баталгаат үйлдвэрлэгчээс нь шууд хэрэглэгчдэд хүргэх нөхцөлийг санхүү, татварын бодлогоор дэмжих					
33	Авто тээврийн хэрэгслийн мэдээллийн санг бий болгох засвар замаар “Үйлчилгээ-Оношилгоо-Хянантын” нэгдсэн системийг бурдуулэх	ЗТБХБЯ	ЗТБХБЯ	ХЭДХЯ	ХЭДХЯ	2012-2020

34	Үүрэн холбооны GSM, хиймэл дагуулын GPS систем дээр сууринсан авто тээврийн хөдлөгөөний бодит хяналтын иж бүрэн системийг Монголын нөхцөлбөр хэрэглэх эрх зүйн орчинг бурдуулан хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	ХЗДХЯ	2012-2015
35	Авто Үйлчилгээний байгууллагудыг антилж стандартын шаардлага хантасан Үйлчилгээ явтуулахад нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах	ЗТБХБЯ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2012-2020
36	Буруу талдаа жолооны хурдтай тээврийн хэрэгслийн хурдний байрлалыг солих, гэрлийн тусгальг өөрчлөх чиглэлээр Үйл ажиллагаа явтуулдаг жижиг, дундг үйлдвэрийг дэмжих замаар буруу талдаа жолооны хурдтай автомашины тоог цөөрүүлэх	ЗТБХБЯ	НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2016
Булэг 4. Хөдөлгөөнд оролцогчод зориулсан арга хэмжээний талаар				
37	Улсын хэмжээнд болтваролын замын байдлын сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	БСШУЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020



38	Хот төвлөлтийг зүйл зохиilstой төлөвлөж, сургууль орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган сургуулийн наасны хувьдийг зам тээврийн осолд өртөхөөс сэргийлэх	ЗТБХБЯ, БСШУЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
39	Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх үнэмлэх олгох тогтолцоог боловсронгуй болгох	ХЗДХЯ, ЗТБХБЯ	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
40	Зөрчил гаргасан жолоочид хариуцлага тооцох журмыг Боловсронгуй болгож, замын хөдөлгөөнд оролцогчдын хулээх хариуцлагын тогтолцоог чангатах	ХЗДХЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
41	Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн Боловсрол олгох, ухамсар, соёлыг төлөвшүүлэх талаар иргэний ниймийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх	ХЗДХЯ	Хэвлэл мэдээлэл, ирээний нийтийн байгууллагууд	2012-2020
42	Хамгаалах малгай, хамгаалах бус, хувьдийн суудал хэрэглэхүүнд хөдөлгөөнд оролцох, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ болон гар утас хэрэглэн тээврийн хэрэгсэл жолдоох зорчилд ногдуулах хариуцлагыг чангатах	ХЗДХЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2013



43	Жолоочийн авч байгаа шалгалт шалгалт авахад шалгалт багасгах шалгатын төвийг байгуулах	3ТБХБЯ, ХЗДХЯ	БСШУЯА, аймаг, нийслэлийн Засаг дарын Тамгын газар	2012-2013
Бүлэг 5. Ослын дараах тусламж, үйлчилгээний талаар				
44	ЭМЧ, ЭМНЭЛГИЙН байгууллагын гэмтлийн Уед үйлчилгээний ажилтан, мэргэжилтнүүдийг авах гарын хангах	холбогдох осол, эмч	3ТБХБЯ, ХЗДХЯ, хандивлагч байгууллагууд	2012-2014
45	Хөдөлгөөнд оролцогчдыг даатгалын системд хамруулан осол, зөрчилд өртөгсдийг эмчэх, эрүүл мэндийг нь нөхөн сартэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох	ЭМЯ	3ТБХБЯ, ХЗДХЯ, Даатгалын өрөнхий газар	2012-2014
46	Осол, гэмтэлд өртөгсдөд үзүүлэх яаралтай болон эмнэлгийн нарийчилсан тусламжийг сайжруулах арга хэмжээ авах	ЭМЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2016
47	Осол, гэмтэлд тандалт хийж тогтолцоог бий болгох	ЭМЯ	3ТБХБЯ, ХЗДХЯ	2012-2015
48	Зам тээврийн ослын улмаас хохирсон хүмүүст тусламж үзүүлэх тогтолцоог бүх сурин газарт бий болгох	ЭМЯ	3ТБХБЯ, ХЗДХЯ	2013-2015



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.2.4, 28.9, 31.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 30.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Нэмэгдэл, мөнгөн урамшлыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгож, шаардагдах хөрөнгийг 2013 оноос эхлэн жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 52 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын “Эрүүл мэнд” гэсэн хэсгийг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2012 оны 150 дугаар
тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАНД НЭМЭГДЭЛ, МӨНГӨН УРАМШИЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн ажилтанд ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь харгалзан мөнгөн урамшил болон нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Нэмэгдэл болон мөнгөн урамшлыг төрийн өмчийн

эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгоно. Хувийн хэвшилийн эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын дагуу нэмэгдэл, мөнгөн урамшил олгож болно.

1.3. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох нэмэгдэл, мөнгөн урамшилд шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага жил бүр төсөвтөө тусган батлуулж байна.

1.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д орсон ажил, албан тушаалыг хашиж байгаа эрүүл мэндийн ажилтан, эх барих-эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, хүүхэд, нярайн эмч болон сувилагчид тухайн ажил, албан тушаалыг хаших хугацаанд нь үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.

1.5. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшлыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзан үндсэн цалингийн 10-15 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно.

Хоёр. Мөнгөн урамшил олгоход баримтлах
шалгуур үзүүлэлт, үнэлгээ, аргачлал

2.1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгоходоо энэхүү журмын 2.2-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт уг урамшилд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэхүү журмын 2.8, 2.10-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно.

2.2. Мөнгөн урамшил олгоход дараах шалгуур үзүүлэлтийг баримтлана:

Албан тушаал	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт
А. Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт		
	Үйлчилгээний чанар	А. Хүлээлгэж чирэгдүүлэлгүй үйлчилгээ үзүүлсэн байдал Б. Ёс зүй, харьцааны байдал В. Үйлчлүүлэгч, хамт олны сээтгэл ханамжийн байдал



Эрүүл мэндийн ажилтан	Ажлын ачаалал, хариуцлага	A. Ажлын цаг ашиглалт Б. Ажлын ачаалал В. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт Г. Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал
	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	A. Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал Б. Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санаалгаачилга гарган ажилласан байдал В. Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал
Б. Тусгай шалгур үзүүлэлт		
Эмнэлгийн мэдрэжилтэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар	A. Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал Б.Халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал В. Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол Г. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөн байдал Д.Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар
Эрүүл мэндийн бусад ажилтан	Хариуцсан ажлын чанар	A. Стандарт мөрдөж байгаа байдал Б. Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар В. Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт

2.3. Эрүүл мэндийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгасан үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх журам, энэхүү журмын 2.2-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг эрүүл мэнд болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

2.4. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг “А”, “В” гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ.

2.5. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшлыг тооцно:

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)
90-100	A	11-15 хувь



71-89	B	10 хувь хүртэл
-------	---	----------------

2.6. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшил олгохгүй.

2.7. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн ажилтны ажиллаж байгаа тасаг, нэгжийн дарга үнэлж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргана.

2.8. Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана.

2.9. Мөнгөн урамшлыг тухайн улирлын дараа сарын 15-ны дотор олгоно.

2.10. Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн бол түүнд тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 15 хувиар тооцож дуудлагаар явсан тохиолдол бүрт нэмэгдэл хөлс олгож байхаар тогтсугай.

2. Алсын дуудлагаар явсан эрүүл мэндийн ажилтны нэмэгдэл хөлсийг тухайн эрүүл мэндийн ажилтны ажиллаж байгаа байгууллагаас, төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явсан эрүүл



мэндийн ажилтны нэмэгдэл хөлсийг уг дуудлагыг өгсөн эрүүл мэндийн байгууллагаас олгож байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатарт даалгасугай.

3. Нэмэгдэл хөлсийг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгож, шаардагдах хөрөнгийг 2013 оноос эхлэн жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД**

Н.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийн “Удирдах албан тушаалтай дүйцүүлэн жишиг мэргэжлийн албан тушаал” гэсэн хэсгийн ТҮЭМ-6 зэрэглэлд “Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн тасгийн эрхлэгч” гэж, ТҮЭМ-5 зэрэглэлд “Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн нэгдэл, аймгийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлэг, тэдгээртэй адилтгах байгууллагын тасгийн эрхлэгч” гэж тус тус нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулж шаардагдах хөрөнгийг 2013 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган



санхүүжүүлж байхыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваад тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД**

Н.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр
бодох цалингийн итгэлцүүр, тэтгэврийн доод
хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5.6, 30 дугаар зүйл, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 3² дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай:

а/ нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийг энэ тогтоолын хавсралтаар баталсан цалингийн итгэлцүүрээр шинэчлэн тогтоож, 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн батлагдсан төсвийн хүрээнд тооцон олгох;

б/ энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан итгэлцүүрийн дагуу тэтгэврийг шинэчлэн тогтооход хэмжээ нь нэмэгдээгүй болон тэтгэврийн нэмэгдсэн хэмжээ нь 23 хувиас бага байгаа иргэдийн одоо авч байгаа тэтгэврийг 23 хувиар нэмэгдүүлэн тооцож 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгох;

в/ 2011 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй



адилтгах орлогын дээд хэмжээг 1,080.000 (нэг сая наян мянган) төгрөгөөр тооцох.

3. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 180.300 (нэг зуун наян мянга гурван зуун) төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 145.200 (нэг зуун дэчин таван мянга хоёр зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр батлах тухай” Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 109 дүгээр тогтоол, “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 80 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ

Засгийн газрын 2012 оны 153 дугаар
тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ
ТЭТГЭВЭР БОДОХ ЦАЛИНГИЙН ИТГЭЛЦҮҮР**

1990 он ба түүнээс өмнөх он	649.00
1991	325.00
1992	159.00
1993	76.00
1994	46.00
1995	14.11
1996	9.33
1997	7.27
1998	5.45
1999	4.81
2000	4.29
2001	4.07



2002	3.79
2003	3.39
2004	2.99
2005	2.74
2006	2.28
2007	1.71
2008	1.21
2009	1.13
2010	1.00

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

**“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэл
эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай
холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2011 оны 57 дугаар тогтоолд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэн бүрт эзэмшүүлэх, үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах, Засгийн газар нэрлэсэн үнээр иргэдийн эзэмшиж байгаа хувьцааг худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Эзэмшиж байгаа хувьцаагаа Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлтэй иргэдийн өргөдлийг хүлээн авч, нэрс болон худалдах хувьцааны тоог нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулах зардалд зориулан 119.3 (нэг зуун арван есөн сая түүнчлийн мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Д.Хаянхярваад зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

Д.ХАЯНХЯРВАА

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ



Засгийн газрын 2012 оны 154 дугээр
тогтоолын хавсралт

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААГ МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БУРТ ЭЗЭМШҮҮЛЭХ,
ҮНДЭСНИЙ АЖ АХУЙН НЭЖУУД ДХУДАЛДАХ, ЗАСГИЙН ГАЗАР ИРГЭДЛИЙН ЭЗЭМШИЖК
БАЙГАУ ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛГАДАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хийх ажил	Хугацаа	Харчуучан хэрэжүүлэх байгууллага	Хамтран хэрэжүүлэх байгууллага
1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШҮҮЛЭХ, ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ БАЛГТЭЛ АЖЛЫГ ХАННАХ			
1 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ИЙН ХУВЬЦААГ ИРГЭДДЭГ ЭЗЭМШҮҮЛЭХ, АЖ АХУЙН НЭЖКИД ХУДАЛДАХТАЙ ХОЛБОДУУЛАН АВАХ ЗАРЫН АРГА ХАМЖЭЭЧНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЖ БАТЛУУЛАХ	IY-Y сард	СЯ	ЗГХЭГ, ТӨХ
Хувьцсаа ЭЗЭМШҮҮЛЭХ, ХУВЬЦААГ ЗАСГИЙН ГАЗАР НЭРЛСЭН УНЭЭР ХУДАЛДАН АВАХ БОЛОН АЖ АХУЙН НЭЖУУДЭД ХУДАЛДАХ АРГА ХАМЖЭЭГ ХЭРЭЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ЗАСГИЙН ГАЗАР БАТЛУУЛАХ	IY-Y сард	СЯ, ХЭДХЯ, ЗТБХЯ, ЗГХЭГ	ТӨХ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Хувьцсаны НАРГЭСЭН УНИЙГ ТОГООХ ТАВААР САНАЛ БОЛОВСРУУЛЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНД ОРУУЛАХ, САНХААГИН ЗОХИУУЛАХААХОРОО, НИЙТИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ, “ҮНЭТ ЧАСНЫ ТӨЛВӨР, ТООЦОО, ТӨВЛӨҮРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК (ЦААШИД “ҮЦТТХТ” ХХК ГЭХ)-НД МЭДЭГДЭХ	IY-Y сард	ТӨХ	“ЭРДЭНЭС МГЛГ” ХХК, “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК
2. Иргэн бурут 1.5 сая төгрөг опгох арга хэмжээний хүрээнд Монгол Улсын нийт иргэнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ИЙН НИЙТ ХУВЬЦАНЫ 20 ХУРЭТХ ХУВИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ			
Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтолцд засвны дагуу хувьцаа ЭЗЭМШИХ ЭРХТЭЙ ИРГЭДИЙН БУРГАЛГИЙН ГАРАЖ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧЛГЭЭНИЙ ГАЗАР, “ҮЦТТХТ” ХХК-НД ХУРГУУЛЭХ, ЭНЭ ТАЛААР НИЙТИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ, САНГИЙН ЯИМААНД МЭДЭЭЛЭХ	IY-Y сард	УБЕГ	
Хувьцатгаа Засгийн Газарт ХУДАЛДАХ ХҮСЭЛГИЙГ ИРГЭДЭСС ХУЛЭЭН АВАХ АРГА, ХАЛБЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ ШААРДНАГАТАЙ БОЛ ЗАСГИЙН ГАЗАРТ ТАНИЛЦУУЛЖ, ШИЙДВЭРГҮҮЛЭХ	IY-Y сард	НХХЯ	СЯ, ТӨХ, “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК



6	Хүний хөгжил сангаас хилиг, хувь хүртсэн тухай мэдээлэлд үндэслэн иргэн бүрийн бэлэн бусаар хүртсэн хишиг, хувьцаа эзэмшигээг тооцон 1.5 сая төгрөгөөс хасн тооцох, хувьцаа эзэмшигээг мөнгөн дунг сум, хороод, аймаг, дүүргэг болон улсын хэмжээнд нэгтгэн гарах, Төрийн ёмчийн хороо, "ЦИТТХТ" ХХК-нд хургуулэх	IY-Y сард	НХХЯ	ХХҮГ
7	Хувьцааг сугтган тооцох, иргэн бүрт эзэмшигүүлэх хувьцааны тоо, нэрс, эзэмшиг хувьцааны тоо, дагалдах мэдээллийг "ЦИТТХТ" ХХК-нд хургуулэх	Ү сард	"Эрдэнэс Тавантолгой" ХК	"ЦИТТХТ" ХХК
8	Хувьцааны нэргээсэн чна, суултан тооцож байгаа зарчим, иртээд ногдох хувьцааны тоо, ширэгээ, застиний газарт хувьцаагаа худалдах хүснэгтийг хэрхэн гарах асуудлаар иртээд мэдээлэл өгөх	Ү сард	ЗГ-ЫН ХМА	НХХЯ, ТӨХ
9	Иргэн бүрт хувьцаа эзэмшигүүлэх, олон нийтэд мэдээлэх, сутгагдсан хувьцааг Хүний хөгжил санд шилжүүлэх	IY-Y сард	ТӨХ, "ЦИТТХТ" ХХК	"Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс МГП" ХХК
3. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 10 хуртэлх хувийг үндэсний аж ахуйн нэгжүүдэд нэргэсэн үнээр худалдах				
10	2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр буюу түүнээс эмне улсын бүртгээд бүртгэдэн үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний аж ахуйн нэгжүүдийн (2011.04. 11-ний өдрийн байдлаар тадаадын хөрөнгө оруулалт 25 хувисас ихгүй) нэрийн гаргаж Татварын өрөнхий газарт хүргүүлэх	IY-Y сард	УБЕГ	Татварын өрөнхий газар
11	Нэг ба түүнээс олон удаа татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжийн нэрийг гарах, тэдэнд нэрс, төлбөр авах дансыг мэдэгдэх, нэг аж ахуйн нэгжид нотдох хувьцааны тоо, ширхэгийг зарлах	Ү сард	Татварын өрөнхий газар	ТӨХ, "ЦИТТХТ" ХХК
12	Үндэсний аж ахуйн нэгжүүдэд хувьцаа худалдах арга, хэлбэр, зарчмыг тодорхойлж. Застиний газарт танилцуулах	IY-Y сард	ТӨХ	УБЕГ, Татварын өрөнхий газар, "ЦИТТХТ" ХХК
13	Үнэт цвасны төлбөр тооцооны байгууллага дээр хувьцаа худалдан авах аж ахуйн нэгжүүдийн төлбөрийг хүрээн авах данс нээж, үндэсний аж ахуйн нэгжүүдэд зарлах	IY-Y сард	"Эрдэнэс МГП" ХХК	"ЦИТТХТ" ХХК



14	Аж ахуйн нэлжүүдийн нэр дээр үнэт цаасны төлбөр тооцоо, хадгамжийн түр данс нээх	Y-YI сард	"ҮЦТТХТ" ХХК	Татварын ерөнхий газар. Брокер, диперийн компаниуд
15	Хувьцаа худалдан авах үндэсний аж ахуйн нэлжүүдийн хүснэгт, төлбөрийн дасгалтаварыг хүзэн авах	Y-YI сард	Татварын ерөнхий газар	Аймаг, дүүргийн татварын хэлтсүүд
16	Хувьцаа худалдаж авах хүснэгт гаргаж төлбөрөө хийсэн аж ахуйн нэлжүүдийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, хувьцаа тоо ширэхийг нэгжтэйн, мэдээллийг "ҮЦТТХТ" ХХК-нд 7 хоног тутамд хүргүүлж байх	Ү сард	Татварын ерөнхий газар	"ҮЦТТХТ" ХХК ТӨХ,
17	Төлбөрийн дасгалтавар, хувьцаа худалдан авах хүснэгтийг үндэслэн хувьцаа худалдан авсан аж ахуйн нэлжүүдийн түр дансанд хувьцааг шилжүүлж дуусгах	Y-YI сард	"ҮЦТТХТ" ХХК	Татварын ерөнхий газар
4. Засгийн газар иргээс хувьцааг нэргэсэн үнээр худалдан авах				
18	Хувьцаагаа нэргэсэн үнээр нь Засгийн газарт худалдах иргэдлийн хүснэгтийг хүзэн авч баталгаажуулах	Ү сард	НХХЯ, ХХҮГ	
19	Хувьцаагаа худалдах иргэдлийн нээс, худалдах хувьцааны тоо, холбогдох мэдээллийг нэлтээн Засгийн газарт танилцуулж, мэдээллийг зарим байгууллагуудад хүргүүлж	Y-YI сард	НХХЯ, ХХҮГ	СЯ, ТӨХ
20	Хувьцаагаа худалдах хүснэгт гаргасан иргээд төлбөрийн нь аж ахуйн нэлжид хувьцаа худалдаан орлогос хархэн санхүүгүүд, аялж шийдвэрлүүлж, Засгийн газар танилцуулж, гарсан шийдвэрийг иргээдэж танилцуулж, иргээд төлбөрийг оптох эхэл	Ү сард	ТӨХ	СЯ, ЗТБХЯ НХХЯ, "Эрдэнэс МГТ" ХХК, "ҮЦТТХТ" ХХК
21	Хувьцаагаа Засгийн газарт худалдах иргэдийн хувьцааг татаж Засгийн газарт төвлөрүүлэх	ҮI сард	ТӨХ	"ҮЦТТХТ" ХХК
22	Үнээсний аж ахуйн нэлжүүдэд хувьцаа худалдаан орлого, иргэдийн Засгийн газар! хувьцаагаа худалдах үйл ажиллагааны дунд үндэслэн хувьцаагаа худалдах иргэдийн хувьцааг багцалж, гадаад, дотоодын хөрөнгө оруулж чадац худалдах нэхцэл, боломжийг судалж, Засгийн газарт танилцуулж чиглэл авах	Y-YI сард	ТӨХ, "Эрдэнэс МГТ" ХХК	СЯ, СЗХ, "ҮЦТТХТ" ХХК



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 161

Улаанбаатар
хот

Төмөр замын суурь бүтцийг барих концессын гэрээний тухай

Концессын тухай хуулийн 19.1, 29.2, 29.3, Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.1, 9.1.2, 23.3, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар, 2012 оны 07/04 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг-Гашуунсуухайт” чиглэлийн төмөр замын ““Сайншандаас Тавантолгой чиглэлд 225 км” төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ”-г “Дорнын төмөр зам” болон “Монголиантранс Лайн” ХХК-тай, ““Ухаахудаг-Гашуунсуухайт” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ”-г “Энержи Ресурс” болон “Энержи Ресурс Рэйл” ХХК-тай энэ тогтооолын 3 дугаар зүйлд заасан нөхцөлийг тусган, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохих журмын дагуу байгуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд зөвшөөрсүгэй.

2.Оросын талтай хэлэлцээ хийж “Дэд бүтцийн хөгжил” ХХК-ийн Монголын талд ногдох хувийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр, уг компанийт ““Ухаахудаг-Тавантолгойгоос Сайншанд чиглэлд 225 км” төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ”-г энэ тогтооолын 3 дугаар зүйлд заасан нөхцөлийг тусган холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

3.Энэ тогтооолын 1, 2 дугаар зүйлд заасан гэрээнд төрийн мэдлийн 51 хувийг төмөр замын суурь бүтцийг барих, ашиглах хугацаанд төлбөртэй, концессын гэрээний хугацаа дууссаны дараа төлбөргүйгээр төрийн өмчид шилжүүлэх, үндэсний хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулж хамтран ажиллах боломжийг хангах, концесс эзэмшигч тус бүрийн хувьцааны тодорхой хувийг Монголын хөрөнгийн биржээр Монгол Улсын иргэдэд нээлттэй арилжаалах, ОХУ-ын далайн боомт хүртэл экспортлох дамжин өнгөрөх ачааны тээврийн тариф, шилжүүлэн ачих нөхцөл өрсөлдөхүйц байлгахад дэмжлэг үзүүлэх үүргийг “Дэд бүтцийн хөгжил” ХХК-д хариуцуулах асуудлыг тус тус тусгахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын



сайд Ц.Дашдорж, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд үүрэг болгосугай.

4.“Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 93 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн “энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хувьцаат компанид” гэснийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д” гэж өөрчилсүгэй.

5.“Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг-Гашуунсуухайт” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих концесст төрийн оролцоо, хяналтыг хангах зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг оролцуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд даалгасугай.

6.Гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төмөр замын суурь бүтцийн барилга байгууламж угсрах болон барилгын ажлыг эхлүүлэхтэй холбогдсон зөвшөөрлийг концесс эзэмшигчид зохих журмын дагуу олгох арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа нарт даалгасугай.

7.“Төмөр замын зурvas газрын болон аюулгүйн бусийн дэглэм батлах тухай” Засгийн газрын 2011 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 6 дугаар тогтоолын дагуу төмөр замын суурь бүтцийг барих зурvas газрын хэмжээг тогтоолго талаар холбогдох арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдоржид, тогтоосон зурvas газрыг концесс эзэмшигчид концессын гэрээнд заасан хугацаанд ашиглуулахыг Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа нарт тус тус үүрэг болгосугай.

8. “Сайншандаас Тавантолгой чиглэлд 225 км” төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Монголиантранс Лайн” ХХК-д, “Ухаахудаг-Тавантолгойгоос Сайншанд чиглэлд 225 км” төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Дэд бүтцийн хөгжил” ХХК-д, “Ухаахудаг-Гашуунсуухайт” чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Энержи Ресурс Рэйл” ХХК-д тус тус олгосугай.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцож, “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 93

дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн ““Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.2-т заасан эхний үе шатанд барих болон Тавантолгой-Ухаахудаг...” гэснийг “Даланзадгад-Тавантолгой”, “Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан” гэж, Засгийн газрын 2010 оны 198 дугаартогтооюор батлагдсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 94 дүгээрт “Уралдаант шалгаруулалт явуулах” гэснийг “Шууд гэрээ байгуулах” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.ДАШДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 5 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар
хот

Монгол Улсын хувьцааг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Европын сэргээн босголт, хөгжлийн банкин дахь Монгол Улсын хувьцааг тус бүр нь 10.0 (арван) мянган еврогийн нэрлэсэн үнэ бүхий 89 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлэхээр тогтсугай.
2. Нэмэгдүүлсэн хувьцаанд шаардагдах хөрөнгийг 2013 оноос эхлэн улсын төсөөт үе шаттайгаар тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

Д.ХАЯНХЯРВАА

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 3.75

Индекс: 14003